

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
СЯ	Соёлын яам

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	19
4. Менежментийн захидал	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН
ЗАХИРАЛ Д.СҮХБААТАР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.02.25 № 07/524
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын үндэсний музейн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд, төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Монголын үндэсний музейн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Монголын үндэсний музейн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зэрэг нийт 18 зорилт бүхий 55 арга хэмжээ тусгасныг хэрэгжүүлэх зорилт тавьж ажилласан байна. Жилийн эцсийн байдлаар дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн гүйцэтгэлийн үнэлгээ дунджаар 95.42 хувьтай байгаа нь ковид-19 цар тахлын улмаас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээ хэрэгжээгүйтэй холбоотой байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд хүлээх төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсөв захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд бол түүнийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	340,383,186.44	304,240,940.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
33	АВЛАГА	2,592,000.00	-
335	Бусад авлага	2,592,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	2,592,000.00	-
34	УРЬДЧИЛГАА	21,105,810.00	-
3471	Урьдчилгаа тооцоо	21,105,810.00	-
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	21,105,810.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	316,685,376.44	304,240,940.80
35300	Бэлэн бүтээгдэхүүн	56,831,451.50	58,699,871.50
354	Хангамжийн материал	259,853,924.94	245,541,069.30
35410	Бичиг хэргийн материал	7,733,400.00	5,063,400.00
35420	Аж ахуйн материал	4,756,530.00	2,286,730.00
35470	Бусад хангамжийн материал	247,363,994.94	238,190,939.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,969,647,191.54	8,877,280,440.48
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,969,647,191.54	8,877,280,440.48
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	8,860,376,780.44	8,768,193,362.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,857,144,733.00	3,857,144,733.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-64,081,811.16	-130,036,657.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	87,133,600.00	87,133,600.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-68,183,600.00	-70,133,600.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,066,517,863.90	1,072,259,733.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-622,231,859.82	-718,969,728.55
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	381,642,463.00	395,161,463.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-76,768,762.04	-115,288,334.25
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	4,272,159,417.00	4,363,877,417.00
39217	Ном	27,044,736.56	27,044,736.56
393	Биет бус хөрөнгө	109,270,411.10	109,087,077.74
39301	Програм хангамж	2,995,000.00	2,995,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,521,388.90	-2,704,722.26
39303	Бусад биет бус хөрөнгө	108,796,800.00	108,796,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,310,030,377.98	9,181,521,381.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,565,629.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,565,629.00	-
413	Өглөг	4,565,629.00	-
4136	Бусад өглөг	4,565,629.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	4,565,629.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,305,464,748.98	9,181,521,381.28
51	Засгийн газрын хувь оролцоо	9,305,464,748.98	9,181,521,381.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,363,714,164.40	1,363,714,164.40
51101	Өмч: - төрийн	1,363,714,164.40	1,363,714,164.40
512	Хуримтлагдсан үр дүн	2,405,274,508.01	2,281,331,140.31
51210	Өмнөх үеийн үр дүн	2,405,274,508.01	2,401,476,202.64
51220	Тайлант үеийн үр дүн	-	-120,145,062.33
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,536,476,076.57	5,536,476,076.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,310,030,377.98	9,181,521,381.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,545,509,311.16	1,297,741,038.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	476,636,266.20	90,139,815.22
120	Нийтлэг татварын бус орлого	476,636,266.20	90,139,815.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	476,636,266.20	88,568,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	476,636,266.20	88,568,000.00
120009	Бусад орлого	-	1,571,815.22
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,068,873,045.16	1,207,601,223.56
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,007,098,300.00	1,146,735,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,007,098,300.00	1,146,735,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,061,774,745.16	60,866,223.56
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	67,628,970.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	213,397,968.00	4,448,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	780,747,807.16	56,418,223.56
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,109,618,681.97	1,417,886,101.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,109,618,681.97	1,417,886,101.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,021,088,978.32	1,206,458,140.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,046,665,198.60	752,790,994.90
210101	Үндсэн цалин	655,029,243.94	577,369,094.03
210102	Нэмэгдэл	35,089,646.00	136,022,900.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,691,000.00	39,399,000.00
210104	Урамшуулал	302,864,922.66	-
210105	Гэрээт ажлын хөлс	8,990,386.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	128,475,868.99	94,274,123.27
210201	Тэтгэврийн даатгал	87,713,242.15	64,850,946.67
210202	Тэтгэмжийн даатгал	10,156,577.42	7,706,724.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,424,397.70	6,111,205.52
210204	Ажилгүйдлийн даатгал	2,031,315.73	1,314,404.17
210205	Эрүүл мэндийн даатгал	20,150,335.99	14,290,841.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,965,372.95	44,134,030.28
210301	Гэрэл, цахилгаан	22,001,232.91	20,368,090.32
210302	Түлш, халаалт	16,868,481.41	21,843,322.14
210303	Цэвэр, бохир ус	3,095,658.63	1,922,617.82
2104	Хангамж, бараа материалын зардал	115,847,499.12	66,117,693.56
210401	Бичиг хэрэг	12,487,038.28	7,132,690.36
210402	Тээвэр, шатахуун	21,361,710.00	1,165,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,687,133.04	3,946,830.02
210404	Ном, хэвлэл	-	3,775,980.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,016,000.00	3,031,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	75,295,617.80	47,065,993.18
2105	Нормативт зардал	2,369,000.00	2,139,160.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,369,000.00	2,139,160.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	216,296,618.80	17,964,747.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,920,000.00	2,097,200.00
210604	Урсгал засвар	213,376,618.80	15,867,547.00
2107	Томилолт, зочны зардал	18,650,100.00	250,000.00
210702	Дотоод албан томилолт	18,648,900.00	250,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,126,114.75	23,382,320.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,305,658.75	15,848,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,018,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	499,606.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	682,460.00	551,860.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,534,600.00	3,494,250.00
210807	Газрын төлбөр	658,200.00	658,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,365,590.00	713,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	393,693,205.11	205,405,071.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,428,628.34	5,591,257.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	67,556,568.00	266,499.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	272,708,008.77	199,547,315.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,529,703.65	211,427,960.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,385,000.00	77,576,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	77,166,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,385,000.00	410,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	76,144,703.65	133,851,960.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,144,703.65	132,954,812.45
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг		897,147.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	435,890,629.39	-120,145,062.33
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,956,420.87	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,956,420.87	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-4,956,420.87	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	430,934,208.52	-120,145,062.33

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,068,729,045.16	1,207,745,223.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,068,729,045.16	1,207,745,223.56
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,007,098,300.00	1,146,735,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,007,098,300.00	1,146,735,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,061,630,745.16	61,010,223.56
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	67,628,970.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	213,397,968.00	4,448,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	780,603,807.16	56,562,223.56
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,921,726,845.16	1,198,344,223.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,921,726,845.16	1,198,344,223.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,831,362,141.51	986,916,263.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,037,022,523.57	763,128,084.58
210101	Үндсэн цалин	645,386,568.91	554,411,082.65
210102	Нэмэгдэл	35,089,646.00	168,773,013.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,691,000.00	39,943,988.33
210104	Урамшуулал	302,864,922.66	-
210105	Гэрээт ажлын хөлс	8,990,386.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	128,475,868.99	86,363,442.37
210201	Тэтгэврийн даатгал	87,713,242.15	59,221,930.35
210202	Тэтгэмжийн даатгал	10,156,577.42	9,203,629.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,424,397.70	3,901,878.35
210204	Ажилгүйдлийн даатгал	2,031,315.73	1,180,305.56
210205	Эрүүл мэндийн даатгал	20,150,335.99	12,855,698.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,795,718.95	44,303,684.28
210301	Гэрэл, цахилгаан	21,831,578.91	20,537,744.32
210302	Түлш, халаалт	16,868,481.41	21,843,322.14
210303	Цэвэр, бохир ус	3,095,658.63	1,922,617.82
2104	Хангамж, бараа материалын зардал	85,871,900.00	22,629,351.02
210401	Бичиг хэрэг	12,620,272.96	2,766,560.00
210402	Тээвэр, шатахуун	17,842,000.00	1,686,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,643,203.04	3,946,830.02
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,016,000.00	3,031,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	48,750,424.00	11,198,761.00
2105	Нормативт зардал	4,424,057.00	2,442,370.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,424,057.00	2,442,370.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	220,847,021.40	21,411,461.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,720,000.00	4,494,200.00
210602	Тавилга	600,000.00	-
210604	Урсгал засвар	213,527,021.40	16,917,261.00
2107	Томилолт, зочны зардал	22,098,600.00	-
210702	Дотоод албан томилолт	18,598,600.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,500,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	175,017,270.00	43,559,020.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	158,290,600.00	29,843,600.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	499,606.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	682,460.00	766,860.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	16,404.00	235,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,800,000.00	3,344,250.00
210807	Газрын төлбөр	658,200.00	658,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,070,000.00	6,613,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	115,809,181.60	3,078,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,373,513.60	993,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	70,435,668.00	2,085,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,364,703.65	211,427,960.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,220,000.00	77,576,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	77,166,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,220,000.00	410,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	76,144,703.65	133,851,960.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,144,703.65	132,954,812.45
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг		897,147.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	147,002,200.00	9,401,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	147,002,200.00	9,401,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	147,002,200.00	9,401,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	147,002,200.00	9,401,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	147,002,200.00	9,401,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-147,002,200.00	-9,401,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,363,714,164.40	5,536,476,076.57	1,976,025,755.34	8,876,215,996.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-1,685,455.85	-1,685,455.85
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,363,714,164.40	5,536,476,076.57	1,974,340,299.49	8,874,530,540.46
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	430,934,208.52	430,934,208.52
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,363,714,164.40	5,536,476,076.57	2,405,274,508.01	9,305,464,748.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-3,798,305.37	-3,798,305.37
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,363,714,164.40	5,536,476,076.57	2,401,476,202.64	9,301,666,443.61
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-120,145,062.33	-120,145,062.33
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,363,714,164.40	5,536,476,076.57	2,281,331,140.31	9,181,521,381.28

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,146,735,000.00	1,013,780,187.55	132,954,812.45	88.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,146,735,000.00	1,013,780,187.55	132,954,812.45	88.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,069,159,000.00	936,204,187.55	132,954,812.45	87.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	844,275,200.00	748,102,909.58	96,172,290.42	88.6
210101	Үндсэн цалин	556,524,600.00	539,635,907.65	16,888,692.35	97.0
210102	Нэмэгдэл	210,890,600.00	168,773,013.60	42,117,586.40	80.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	76,860,000.00	39,693,988.33	37,166,011.67	51.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,977,300.00	85,201,004.67	28,776,295.33	74.8
210201	Тэтгэврийн даатгал	80,206,200.00	58,059,492.65	22,146,707.35	72.4
210202	Тэтгэмжийн даатгал	8,442,700.00	9,203,629.90	-760,929.90	109.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,754,200.00	3,901,878.35	2,852,321.65	57.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,688,600.00	1,180,305.56	508,294.44	69.9
210205	Эрүүл мэндийн даатгал	16,885,600.00	12,855,698.21	4,029,901.79	76.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,962,300.00	38,461,582.28	3,500,717.72	91.7
210301	Гэрэл, цахилгаан	15,981,500.00	17,289,766.32	-1,308,266.32	108.2
210302	Түлш, халаалт	22,988,000.00	19,249,198.14	3,738,801.86	83.7
210303	Цэвэр, бохир ус	2,992,800.00	1,922,617.82	1,070,182.18	64.2
2104	Хангамж, бараа материалын зардал	16,618,600.00	16,554,551.02	64,048.98	99.6
210401	Бичиг хэрэг	2,223,700.00	2,071,560.00	152,140.00	93.2
210402	Тээвэр, шатахуун	1,482,700.00	1,482,000.00	700.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,396,200.00	3,715,830.02	-319,630.02	109.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,103,700.00	1,988,000.00	115,700.00	94.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,412,300.00	7,297,161.00	115,139.00	98.4
2105	Нормативт зардал	2,223,700.00	1,877,370.00	346,330.00	84.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,223,700.00	1,877,370.00	346,330.00	84.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	647,500.00	647,500.00	-	100.0
210604	Урсгал засвар	647,500.00	647,500.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,231,600.00	42,374,020.00	3,857,580.00	91.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,501,800.00	28,658,600.00	2,843,200.00	91.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	825,400.00	98,010.00	727,390.00	11.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	774,600.00	766,860.00	7,740.00	99.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	398,400.00	235,000.00	163,400.00	59.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,350,000.00	3,344,250.00	5,750.00	99.8
210807	Газрын төлбөр	658,200.00	658,200.00	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,723,200.00	6,613,100.00	110,100.00	98.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,222,800.00	2,985,250.00	237,550.00	92.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	906,000.00	900,000.00	6,000.00	99.3

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,316,800.00	2,085,250.00	231,550.00	90.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,576,000.00	77,576,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	77,576,000.00	77,576,000.00	-	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	77,166,000.00	77,166,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	410,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,146,735,000.00	1,013,780,187.55	132,954,812.45	88.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,146,735,000.00	1,013,780,187.55	132,954,812.45	88.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,146,735,000.00	1,013,780,187.55	132,954,812.45	88.4
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	-	-		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	61	61		100.0
620001	Удирдах ажилтан	1	1		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	41	41		100.0
620003	Үйлчлэх ажилтан	19	19		100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	61,010,223.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	61,010,223.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	60,113,075.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	15,025,175.00
210101	Үндсэн цалин		14,775,175.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		250,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	1,162,437.70
210201	Тэтгэврийн даатгал		1,162,437.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	5,842,102.00
210301	Гэрэл, цахилгаан		3,247,978.00
210302	Түлш, халаалт		2,594,124.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,074,800.00
210401	Бичиг хэрэг		695,000.00
210402	Тээвэр, шатахуун		204,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		231,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,043,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,901,600.00
2105	Нормативт зардал	-	565,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		565,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	27,014,961.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		9,029,200.00
210602	Тавилга		1,716,000.00
210604	Урсгал засвар		16,269,761.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	4,335,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		4,335,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	93,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		93,600.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	897,147.86
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		897,147.86
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	61,010,223.56
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	61,010,223.56
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,448,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	56,562,223.56
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монголын үндэсний музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Захирал Д.Сүхбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, санхүүгийн программд хөгжүүлэлт хийх, дотоод хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 1 дүгээр сарын 15-наас 2021 оны 2 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 2 дугаар сарын 24-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Мэжик консалтинг аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Монголын үндэсний музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Монголын үндэсний музейн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Өөрийн цуглуулгыг шинжлэх ухааны арга зүйд тулгуурлан судалж, цуврал бүтээлүүд хэвлүүлэх, үзүүлэнгийн танхимуудыг сайжруулан олон улсын стандартад нийцүүлэх, археологи, түүх, угсаатны хээрийн болон суурь судалгааны ажлыг гүнзгийрүүлэн олон улсын түвшинд хамтран ажиллах, хээрийн болон суурь судалгаанд шаардлагатай орчин үеийн тоног төхөөрөмжүүдтэй болох, түүнийг ашиглах арга зүйд суралцах, судлаачдыг дотоод гадаадад нарийн мэргэжлийн сургалтад хамруулахад оршино” гэж тодорхойлжээ.

Монголын үндэсний музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Соёлын өвийг хадгалж хамгаалан хойч үедээ уламжлуулах
- Иргэдийн оюуны тодорхой эрэлт хэрэгцээг хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орсныг хэрэгжүүлж ажилласан байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Монголын үндэсний музейн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Соёлын яамны “Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар” 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн боловч дотоод аудитын тайланг ирүүлээгүй байна.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 728,542.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,285.4 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн шатанд жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,417,886.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 14,178. мянган төгрөгөөр материаллаг байдлыг дахин тооцов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монголын үндэсний музейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 128,509.0 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо /эздийн өмч/-ийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	2,592.0		-2,592.0
Урьдчилгаа	21,105.8		-21,105.8
Бараа материал	316,685.4	304,240.9	-12,444.4
Үндсэн хөрөнгө	8,969,647.2	8,877,280.4	-92,366.8
Нийт хөрөнгө	9,310,030.4	9,181,521.4	-128,509.0
Өр төлбөр	4,565.6		-4,565.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,305,464.7	9,181,521.4	-123,943.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,310,030.4	9,181,521.4	-128,509.0

Авлага дансны үлдэгдэл 2,592.0 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагаас авах авлагыг барагдуулснаас шалтгаалжээ.

Урьдчилгаа тооцоо дансны үлдэгдэл 21,105.8 мянган төгрөгөөр буурсан нь “Грийн хими” ХХК-тай 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн №СН19/62 тоот худалдан авах гэрээний дагуу үндсэн хөрөнгө, бараа материал хүлээн авснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 304,240.9 мянган төгрөг болж 12,144.4 мянган төгрөгөөр буурсан нь бэлэн бүтээгдэхүүн 1,868.4 мянган төгрөгөөр өсөж, бичиг хэргийн материал 2,670.0 мянган төгрөг, аж ахуйн материал 2,469.8 мянган төгрөг, бусад хангамжийн материал 1,233.4 мянган төгрөгөөр тус тус буурч, 7,939.6 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг актласнаас шалтгаалжээ. Бараа материалын дансны

үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна. Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүссэн асуудал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,877,280.4 мянган төгрөг болж 92,366.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны урьдчилгаа тооцооноос 16,259.9 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 9,401.0 мянган төгрөг, хандив болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн булшны олдвор нийт 88,568.0 мянган төгрөгийн хөрөнгөөр өсөж, тайлант хугацааны элэгдлийн зардлын өсөлтөөс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4,565.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд үүссэн ХХОАТ-ын өр болон цахилгааны төлбөрийг төлж барагдуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,181,521.4 мянган төгрөг болж 123,943.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны үр дүн болон нягтлан бодох бүртгэлийн алдааны залруулга 3,798.3 мянган төгрөгөөс шалтгаалжээ.

Монголын үндэсний музейн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,297,741.0 мянган төгрөгөөр буюу 51 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт, төсөвт байгууллагын өөрийн орлого, нэмэлт санхүүжилтийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого байна. Энэ нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт 139,636.7 мянган төгрөгөөр өсөж, ковид-19 цар тахлаас шалтгаалан музейн үндсэн үйл ажиллагааны орлого 724,329.6 мянган төгрөг, бусад нэмэлт санхүүжилтийн орлого 276,579.0 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 691,732.6 мянган төгрөгөөр буюу 67.21 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ, хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж зэрэг зардлууд байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 293,874.2 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ 34,201.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 49,729.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 198,331.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 33,743.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 188,288.1 мянган төгрөгөөр тус тус буурч, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 77,166.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнрүү хаасан 3,798.3 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь элэгдлийн зардлыг дутуу байгуулснаас шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,173,815.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,173,815.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 10,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,183,815.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлсийг 17,314.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, бараа үйлчилгээний бусад зардлыг

7,314.3 мянган төгрөгөөр бууруулсантай холбоотой байна. Төсвийн тодотголоор төсвийг 37,080.2 мянган төгрөгөөр бууруулж, 1,146,735.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,146,735.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,146,735.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,146,735.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 1,146,735.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,013,780.2 мянган төгрөгийг зарцуулж 132,954.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,013,780.2 мянган төгрөг буюу 88.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 96,172.3 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 28,776.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,500.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, хангамж, үйлчилгээний төлбөр хураамж 3,857.6 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардал 64.0 мянган төгрөг, норматив зардал 346.3 мянган төгрөг, төлбөр хураамжийн зардлыг 3,857.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн хэмнэлт нь 2020 оны 1 болон 3 улиралд үр дүнгийн урамшуулал олгогдоогүйгээс цалингийн зардал 96,172.3 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 28,776.3 мянган төгрөг, ковид-19 цар тахлаас шалтгаалан байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,500.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 3,857.6 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардал 64.0 мянган төгрөг, норматив зардал 346.3 мянган төгрөг, төлбөр хураамжийн зардлыг 3,857.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 4,448.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 56,562.2 мянга, нийт 61,010.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 15,025.2 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 1,162.4 мянга, байр ашиглалттай холбоотой нэмэгдэл зардалд 5,842.1 мянга, хангамж, бараа материалын зардалд 6,074.8 мянга, норматив зардалд 565.0 мянга, эд хогшил худалдан авах зардалд 27,015.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс 4,335.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 93.6 мянга нийт 60,113.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 897.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 161 мэдээллээс хугацаандаа оруулсан 127 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 28 мэдээлэл, 4 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны бүртгэлийн системд оруулбал зохих 161 мэдээллээс 127 мэдээллийг хугацаанд нь оруулсан, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 28 мэдээлэл, 4 мэдээллийг байршуулаагүй ба 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 удаагийн 16,374.4 мянган төгрөгийн орлогыг мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 20,613.4 мянган төгрөгийн зөрчилд 1,609.4 мянган төгрөгийн төлбөрийн акт, 11,846.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 7,157.6 мянган төгрөгийн албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 11,846.3 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,609.4	2	1,609.4	-	-	100
Албан шаардлага	1	7,157.6	1	7,157.6	-	-	100
Зөвлөмж	4	11,846.3	4	11,846.3	-	-	100
Нийт дүн	7	20,613.4	7	20,613.4	-	-	100

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 156,120.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 112,221.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,530.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 17,324.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 25,043.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үр дүнгийн тайланд тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 77,166.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлаар тайлагнасан.
2. Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд урьдчилгаа тооцооноос хүлээн авсан 4,456.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 11,803.0 төгрөгийн тавилга эд хогшлыг хандиваар авсан хөрөнгөөр бүртгэж тайлагнасан.
3. Бараа материалын тодруулгад тайланд урьдчилгаа тооцооноос хүлээн авсан 4,845.9 мянган төгрөгийн бараа материал, ангилал шилжүүлэн бүртгэсэн 4,340.0 мянган төгрөгийн хангамжийн материалыг хандиваар бүртгэж тайлагнасан.
4. Хөрөнгийг ангилал хооронд шилжүүлэн бүртгэхдээ 820.0 төгрөгөөр үндсэн хөрөнгө борлуулсны олз хэмээн үр дүнгийн тайланд буруу бичилт хийж тайлагнасан.
5. Сахилгын шийтгэлийн 1,571.8 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэж тайлагнасан.
6. Санхүүгийн байдлын тайланд бараа материалыг 270.0 мянган төгрөгөөр илүү бүртгэж, санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэж тайлагнасан.

7. Түүх, соёлын дурсгалт зүйл 3,150.0 мянган төгрөгийн уран зургийг тавилга эд хогшил дансанд бүртгэж тайлагнасан.
8. Компьютер түүнтэй адилтгах 9 хөрөнгийн өмнөх тайлант хугацаанд хамаарах 3,798.3 мянган төгрөгийн элэгдлийг тайлант хугацааны элэгдлийн зардлаар бүртгэж тайлагнасан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 18,854.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,530.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 17,324.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Гэрээт 24 ажилтанд олгосон ажлын хөлсөнд 1,530.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлж, татвар дутуу ногдуулсан байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1.6-д *“үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого,”* 23.1-д *“Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ”* гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 182/ШШ2020/01702 дугаар шийдвэрийг үндэслэн нэр бүхий ажилтанд ажилгүй байсан хугацааны 950.5 мянган төгрөгийн нөхөн төлбөрийг, байгууллагын төсвөөс олгосон байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-д *“Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.”* гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3. Шилэн дансны нэгдсэн цахим системд 28 мэдээллийг хоцроож, 4 мэдээллийг байршуулаагүй ба 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 удаагийн 16,374.4 мянган төгрөгийн орлогыг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т *“мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”*, 4.1.3-т *“тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”*, 6 дугаар зүйлийн 6.4-д *“Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг,”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дэлхий нийтийг хамарсан ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, хөрөнгийн болон бараа материалын биет тооллого хийх, төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгө, бараа материалын дансны үлдэгдлийг баталгаажуулах, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хянах зорилгоор тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшилд хэсэгчилсэн гэнэтийн тооллого хийхэд үндсэн хөрөнгийн код дутуу, зарим код зөрүүтэй, эд хариуцагч хоорондын шилжилт хөдөлгөөнийг тухай бүр бүртгээгүй, эд хариуцагчийн нэр зөрүүтэй зөрчил илэрч байна.

1.2. Эрсдэл:

Үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт алдагдах, хөрөнгө үрэгдэх, хууль, заавар журам зөрчигдөх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 2-т “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Үндсэн хөрөнгийн кодыг шинэчилж, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг тухай бүр нь бүртгэж тайлагнаж байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, хариу тайлбарыг албан бичгээр ирүүлсэн.

2. Анхан шатны баримттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Касс, харилцахын дансны орлого болон худалдан авалтыг цахим баримттай тулган шалгахад өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогыг төлбөрийн цахим баримтад бүртгээгүй, худалдан авалтын цахим баримтгүй 25,043.2 мянган төгрөгийн 32 ажил гүйлгээ, бараа материалын зарлагын баримт үйлддэггүй, баримтыг урьдчилан дугаарладаггүй байна.

2.2. Эрсдэл:

Хууль, тогтоомж заавар, журам зөрчигдөх

2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, мөн сангийн сайдын 2017 оны 12 сарын 5-ны 347 тоот тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааварын нэгдүгээр зүйлд “...Аж ахуйн нэгж, байгууллага нь анхан шатны маягтуудыг нэгдсэн журмаар урьдчилан дугаарлана.”, гуравдугаар зүйлд “Материал, үнэ бүхий зүйлийн хөдөлгөөнийг эд хариуцагчид “Бараа, материалын үнэ бүхий зүйлийн орлого, зарлагын баримт”-ыг үндэслэн агуулахын бүртгэлийг биет нэгжээр хөтөлж өдөр тутмын үлдэгдлийг тодорхойлохын хамт тайлант хугацаанд хариуцагч нягтлан бодогчоор тайлангаа хянуулж үлдэгдлийг батлуулан гарын үсэг зуруулна.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого болон худалдан авалтыг төлбөрийн цахим бүртгэлийн системд бүрэн бүртгэж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

3. Санхүүгийн программтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Санхүүгийн программын үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд өмнөх тайлант хугацаанд шилжүүлэн хүлээн авсан хөрөнгийн элэгдлийг тайлант хугацаанд хөрөнгө шилжиж ирсэн мэт харуулж хуримтлагдсан элэгдлийн дүнг илүү харагдуулж байна.

3.2. Эрсдэл:

Үндсэн хөрөнгийн тайлан буруу бэлтгэгдэх.

3.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага” 1.4 болон 2.2-т заасан шаардлагатай нийцэхгүй байна.

Санхүүгийн программын тохиргоог хийлгэж, зөрчлийг арилгах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тус байгууллага асуудлын бүртгэлтэй танилцаж, хариу тайлбарыг албан бичгээр ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Монголын үндэсний музей 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02.20			САГ-2021/212/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Монголын үндэсний музей		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 182/ШШ2020/01702 дугаар шийдвэрийг үндэслэн нэр бүхий ажилтанд ажилгүй байсан хугацааны 950.5 мянган төгрөгийн нөхөн төлбөрийг, байгууллагын төсвөөс олгосон байна.	950.5	Албан шаардлага өгөх	Захирал Ерөнхий нягтлан	Д.Сүхбаатар Ж.Батсүх
2	Гэрээт 24 ажилтанд олгосон ажлын хөлсөнд 1,530.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт тооцож, татвар дутуу ногдуулсан.	1,530.0	Төлбөрийн акт тогтоох	Захирал Ерөнхий нягтлан	Д.Сүхбаатар Ж.Батсүх
3	Үндсэн хөрөнгө, бараа материалын дансны үлдэгдлийг баталгаажуулах, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хянах зорилгоор тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшилд хэсэгчилсэн гэнэтийн тооллого хийхэд үндсэн хөрөнгийн код дутуу, зарим код зөрүүтэй, эд хариуцагч хоорондын шилжилт хөдөлгөөнийг тухай бүр бүртгээгүй, эд хариуцагчийн нэр зөрүүтэй зөрчил илэрч байна.		Зөвлөмж өгөх	Захирал Ерөнхий нягтлан	Д.Сүхбаатар Ж.Батсүх
4	Касс, харилцахын дансны орлого болон худалдан авалтыг цахим баримттай тулган шалгахад өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогыг төлбөрийн цахим баримтад бүртгээгүй, худалдан авалтын цахим баримтгүй 25,043.2 мянган төгрөгийн 32 ажил гүйлгээ, бараа материалын зарлагын баримт үйлддэггүй, баримтыг урьдчилан дугаарладаггүй байна.	25,043.2	Зөвлөмж өгөх	Захирал Ерөнхий нягтлан	Д.Сүхбаатар Ж.Батсүх
5	Санхүүгийн программын үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд өмнөх тайлант хугацаанд шилжүүлэн хүлээн авсан хөрөнгийн элэгдлийг тайлант хугацаанд хөрөнгө шилжиж ирсэн мэт харуулж хуримтлагдсан элэгдлийн дүнг илүү харагдуулж байна.	-	Зөвлөмж өгөх	Захирал Ерөнхий нягтлан	Д.Сүхбаатар Ж.Батсүх
6	Шилэн дансны нэгдсэн цахим системд 28 мэдээллийг хоцроож, 4 мэдээллийг байршуулаагүй ба 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 удаагийн 16,374.4 мянган төгрөгийн орлогыг мэдээлээгүй байна.	16,374.4	Албан шаардлага өгөх	Захирал Ерөнхий нягтлан	Д.Сүхбаатар Ж.Батсүх
ДҮН		43,898.1			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 98/40140069

Улаанбаатар хот

САГ-2021/412/СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монголын үндэсний музейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монголын үндэсний музей нь 24 гэрээт ажилтанд 1,530,000.00 /нэг сая таван зуун гучин мянган/ төгрөгийн хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлж, татварыг дутуу ногдуулсан байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1.6 -д "үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;" 23.1-т "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хувь хүний орлогын албан татварыг дутуу ногдуулсан 1,530,000.00 /нэг сая таван зуун гучин мянган/ төгрөгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монголын үндэсний музейн захирал Д.Сүхбаатар, ерөнхий нягтлан бодогч Ж.Батсүх нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР
МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ДАШДАВАА

С.МӨНХБАЯР

801090490



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 128/A0140069

Улаанбаатар хот

САГ-1021/212/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монголын үндэсний музейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 182/ШШ2020/01702 дугаар шийдвэрийг үндэслэн нэр бүхий ажилтанд ажилгүй байсан хугацааны 950,544.00 /есөн зуун тавин мянга таван зуун дөчин дөрвөн/ төгрөгийн нөхөн төлбөрийг, байгууллагын төсвөөс олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөрт олгосон 950,544.00 /есөн зуун тавин мянга таван зуун дөчин дөрвөн/ төгрөгийн төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2021 оны 6 сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын үндэсний музейн захирал Д.Сүхбаатар, ерөнхий нягтлан бодогч Ж.Батсүх нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР
МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ДАШДАВАА

С.МӨНХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 129/А0140069

Улаанбаатар хот

САГ-2021/012/СТА-ТМЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монголын үндэсний музейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим системд 28 мэдээллийг хоцроож, 4 мэдээллийг байршуулаагүй ба 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 удаагийн 16,374,420.00 /арван зургаан сая гурван зуун далан дөрвөн мянга дөрвөн зуун хорин/ төгрөгийн орлогыг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь, ил тод, бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын үндэсний музейн захирал Д.Сүхбаатар, ерөнхий нягтлан бодогч Ж.Батсүх нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР
МЭЖИК КОНСАЛТИНГ АУДИТ ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Ч.ДАШДАВАА

С.МӨНХБАЯР

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of numerous horizontal rows, each defined by two parallel dotted lines. The rows are evenly spaced and extend across the entire width of the page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.

[illegible]